



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар Б/21

Хэрлэн сум

Музейн бүтэц, орон тоог  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2. Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Музейн шинэ барилга ашиглалтад орж, MNS5634:2006 стандартын дагуу орон тоо нэмэгдэх шаардлагатай болсон тул музейн бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажлын байрыг оновчтой тогтоон, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, гэрээ байгуулж, хэвийн үйл ажиллагаагаар хангаж ажиллахыг Музейн захирал (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын 05-ны Б/33 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны дүгээр сарын...-ны өдрийн... дугаар захирамжийн хавсралт

### ХЭНТИЙ АЙМГИЙН МУЗЕЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

